



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 8701

Говьсүмбэр аймаг

Г

Э.Сарантуяаг ажилд  
томилох тухай

Г

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэмж сайн дурын даатгалын байцаагч Э.Сарантуяа нь хүүхдээ асрах чөлөөтэй байгаад ажилдаа буцаан орох хувийн өргөдлийг гаргасан тул 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажилд нь томилсугай.

2.Тэтгэмж сайн дурын даатгалын байцаагчийн ажлыг гүйцэтгэж байсан Б.Мөнхцэцэгийг 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Б.Мөнхцэцэг, Э.Сарантуяа нарын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

П.ГАНТУЯА

(ЭМД-ын байцаагч, сангийн нягтлан бодогч)

Гишүүд:

О.БАЙГАЛЬСАЙХАН

(Орлого, шимтгэлийн байцаагч)

Т.НАЦАГМАА

(Хүний нөөц, бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан)

Ч.ХАТАНТӨМӨР

(Үйлчлэгч)

Г.БАТТУЛГА

(Харуул)

3.Э.Сарантуяагийн албан тушаалын сарын үндсэн цалинг (ТЗ-7) шатлалаар 924,456 (есөн зуун хорин дөрөв дөрвөн зуун тавин ёс) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 3%, орон нутгийн нэмэгдэл 20%, унаа хоолны

нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 57ас.

Говьсүмбэр аймаг

┌ **Б.Мөнхцэцэгийг шилжүүлэн** ┐  
**ажиллуулах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэмж сайн дурын даатгалын байцаагч Б.Мөнхцэцэгийн хувийн өргөдлийн харгалзан үзээд 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс Тэтгэмж, сайн дурын даатгалын байцаагчаас чөлөөлж, Шивээговь сумын байцаагчаар томилсугай.

2.Б.Мөнхцэцэгийн ажил хүлээлцэх ажлын хэсгийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

**Ц.БЯМБАСҮРЭН**

(Үйлчилгээний тасгийн дарга, хяналт шалгалт , дотоод аудитын байцаагч)

**О.БАЙГАЛЬСАЙХАН**

(Орлого, шимтгэлийн байцаагч)

**Т.НАЦАГМАА**

(Хүний нөөц, бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан)

**Ч.ХАТАНТӨМӨР**

(Үйлчлэгч)

**Г.БАТТУЛГА**

(Харуул)

3.Б.Мөнхцэцэгийн албан тушаалын сарын үндсэн цалинг (ТЗ-9) шатлалаар 791,532 (Долоон зуун ерөн нэг таван зуун гучин хоёр) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 9%, зэрэг дэвийн нэмэгдлийг 22%, орон нутгийн нэмэгдэл 20% тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 503.

Говьсүмбэр аймаг

Г Б.Отгонсүрэнг ажилд томилох тухай Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж, авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2022 оны ХЭГ/3167 дугаар албан тоот, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны 03/3458 дугаар албан тоот, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний Б/15 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар татан буугдсантай холбогдуулан Говьсүмбэр аймгийн мэргэжлийн хяналтын газрын нийгмийн хамгааллын улсын ахлах байцаагч Баярсайны Отгонсүрэнг 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтэст нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагчаар томилон ажиллуулсугай.

2. Б.Отгонсүрэнгийн ашиглаж байсан компьютер техник, хэрэгсэл, эд хөрөнгийг хүлээн авч хөрөнгийн бүртгэлд бүртгэхийг А.Мягмаржамцад даалгасугай.

3. Б.Отгонсүрэнгийн үндсэн цалин (ТЗ-6) шатлалаар 1,002,648 төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10%, орон нутгийн нэмэгдэл 20%, зэрэг дэвийн нэмэгдэл 20%, унаа хоолны нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА 

Г.ГҮРРАГЧАА



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5704.

Говьсүмбэр аймаг

### Г ЭБАТ-ын нэмэгдэл Г олгох тухай

Монгол Улсын их хурлын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын байцаагч, сангийн нягтлан бодогч Пүрэвийн Гантуяа нь албан тушаалын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг хүлээн авах, бүртгэх, хянах, хадгалах ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 01-нэс өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил хавсран гүйцэтгэж байгаа П.Гантуяаг хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцыг чандлан хадгалж, хэлтсийн авлигын төлөвлөгөө гаргах түүнийг хэрэгжүүлэх, авилгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж, чанартай хариуцлагатай ажиллаж, хийсэн ажлын тайланг хагас бүтэн жилээр биелэлтийг гаргаж хэлтсийн даргад танилцуулахыг үүрэг болгосугай.

3. П.Гантуяад олгох нэмэгдэл 331,119 (гурван зуун гучин нэг зуун арван ёсон) төгрөгийг цалин сангаас олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан хэлтсийн даргын 2015 оны 03 дугаар сарын 02-ний Б/11 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5705.

Говьсүмбэр аймаг

**А.Мягмаржамцыг ажлаас  
чөлөөлөх тухай**

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, нэг цонх хариуцсан байцаагч А.Мягмаржамц нь ажлаас чөлөөлөгдөх хувийн өргөдөл гаргасан тул 2023 оны 01 дугаар сарын 31-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.А.Мягмаржамцын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

**Ө.САЙНХҮҮ**

(Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч)

Гишүүд:

**П.ГАНТУЯА**

(ЭМД-ын байцаагч, сангийн нягтлан бодогч)

**Т.НАЦАГМАА**

(Хүний нөөц, бичиг хэрэг, архивын ажилтан)

3.А.Мягмаржамцтай холбогдох тооцоог 2023 оны 01 дүгээр сарын 31-ний дотор дуусгахыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д үүрэг болгосугай.



**ДАРГА**

**Г.ГҮРРАГЧАА**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 5706

Говьсүмбэр аймаг

Ө.Сайнхүүд ажил хавсран  
гүйцэтгэсний нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч Ө.Сайнхүүг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн няравын ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 40% тооцон олгохыг ахлах нягтлан бодогч (П.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Няравын албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийн хүрээнд чанартай гүйцэтгэж ажиллахыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр


Дугаар 5144.

Говьсүмбэр аймаг

Орон тооны бус төлөөлөгч  
томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5, Иргэний хуулийн 359 дугаар зүйлийн 359.1, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2000 оны 04 дүгээр сарын 14-ны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн орон тооны бус төлөөлөгчөөр Сосорын Саранцэцэгийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн томилсугай.
3. С.Саранцэцэгийн албан тушаалын сарын үндсэн цалинг хөлсөөр ажиллах гэрээний дагуу 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгөөр олгохыг Төлөвлөлт, нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.
4. Хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргийг ханган ажиллахыг (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Г.ГҮРРАГЧАА





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 5708.

Говьсүмбэр аймаг

Д.Нацагдоржийг ажлаас  
чөлөөлөх тухай

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн жолооч Даваасамбуугийн Нацагдорж нь ажлаас чөлөөлөгдөх хувийн өргөдөл гаргасан тул 2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Д.Нацагдоржийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ө.САЙНХҮҮ

(Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч)

Гишүүд:

П.ГАНТУЯА

(ЭМД-ын байцаагч, сангийн нягтлан бодогч)

Т.НАЦАГМАА

(Хүний нөөц, бичиг хэрэг, архивын ажилтан)

3.Д.Нацагдоржтой холбогдох тооцоог 2023 оны 02 дугаар сарын 15-ний дотор дуусгахыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 5709

Говьсүмбэр аймаг

Г Д.Жаргалсайханг ажилд томилох тухай Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 488 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн жолоочийн сул орон тоо дээр Даваасамбуугийн Жаргалсайханыг 2023 оны 02 дугаар сарын 16-ний өдрөөс эхлэн томилсугай.

3.Д.Жаргалсайханы ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

**П.ГАНТУЯА**

(ЭМД-ын байцаагч, сангийн нягтлан бодогч)

Гишүүд:

**О.БАЙГАЛЬСАЙХАН**

(Орлого, шимтгэлийн байцаагч)

**Т.НАЦАГМАА**

(Хүний нөөц, бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан)

3.Д.Жаргалсайханд албан тушаалын сарын үндсэн цалинг (ТҮ-3) шатлалаар 615,152 төгрөгөөр, унаа хоолны нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 5100 .

Говьсүмбэр аймаг

### Т.Нацагмаад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгох тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн Хүний нөөц, бичиг хэрэг, архивын ажилтан Т.Нацагмаад 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, нэг цонх хариуцсан байцаагчийн ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 40% тооцон олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, нэг цонх хариуцсан байцаагчийн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийн хүрээнд чанартай гүйцэтгэж ажиллахыг Хүний нөөц, бичиг хэрэг, архивын ажилтан (Т.Нацагмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 57М.

Говьсүмбэр аймаг

### Ч.Хатантөмөрийг төрийн албанаас чөлөөлөх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн үйлчлэгч Ч.Хатантөмөр нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул хөдөлмөрийн гэрээг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр цуцалж, ажлаас чөлөөлсүгэй.

2.Төрийн үйлчилгээний албанаас чөлөөлөгдөж байгаатай холбоотой Ч.Хатантөмөрт олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид шаардагдах 12,038,300 (арван хоёр сая гучин найман мянга гурван зуу) төгрөг, ажилласан хугацааны амралтын мөнгийн зохих журмын дагуу олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 57/12

Говьсүмбэр аймаг

Г  
Нууц хамгаалах ажилтан  
томилох тухай  
Г

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.3 дахь хэсгийг тус тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн Орлого, шимтгэлийн байцаагч О.Байгальсайханг байгууллагын сургалт сурталчилгаа, нууц хамгаалах ажилтнаар 2023 оны 02 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.О.Байгальсайханд албан тушаалын үндсэн цалингийн 30 хувь нэмэгдлийг олгосугай.

3.Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн ажиллах, холбогдох албан тушаалтнуудад хяналт тавьж ажиллахыг О.Байгальсайханд үүрэг болгосугай.



ДАРГА  
Г.ГҮРРАГЧАА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 5713.

Говьсүмбэр аймаг

Г

Н.Доржмааг ажилд  
томилох тухай

Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 488 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн үйлчлэгчийн сул орон тоо дээр Нацагийн Доржмааг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

3.Н.Доржмааг ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

П.ГАНТУЯА

(ЭМД-ын байцаагч, сангийн нягтлан бодогч)

Гишүүд:

О.БАЙГАЛЬСАЙХАН

(Орлого, шимтгэлийн байцаагч)

Т.НАЦАГМАА

(Хүний нөөц, бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан)

3.Н.Доржмаагийн албан тушаалын сарын үндсэн цалинг (ТҮ-1) шатлалаар 565,277 төгрөгөөр, унаа хоолны нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГҮРРАГЧАА



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 5114.

Сүмбэр сум

**Б.Мөнхцэцэгийг ажилд  
томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шивээговь сумын байцаагч Б.Мөнхцэцэгийн хувийн өргөдлийн харгалзан үзээд 2023 оны 03 дугаар сарын 01-нээс Шивээговь сумын байцаагчаас чөлөөлж, мөн өдрөөс Мэдээллийн технологи, эрүүл мэндийн даатгалын байцаагчаар томилсугай.

2.Б.Мөнхцэцэгийн ажил хүлээлцэх ажлын хэсгийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

**Ц.БЯМБАСҮРЭН**

(Үйлчилгээний тасгийн дарга, хяналт шалгалт , дотоод аудитын байцаагч)

**О.БАЙГАЛЬСАЙХАН**

(Орлого, шимтгэлийн байцаагч)

**Ө.САЙНХҮҮ**

(Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч)

Гишүүд:

3.Б.Мөнхцэцэгийн албан тушаалын сарын үндсэн цалинг (ТЗ-9) шатлалаар 791,532 (Долоон зуун ерөн нэг таван зуун гучин хоёр) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 9%-иар, зэрэг дэвийн нэмэгдлийг 22%-иар, орон нутгийн нэмэгдэл 20%, унаа хоолны нэмэгдлийг ажилласан өдрөөр тооцон олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Г.ГҮРРАГЧАА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 57/05.

Говьсүмбэр аймаг

**Ө.Сайнхүүд урамшуулал  
олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3 дахь хэсгийн 3.2.5, Говьсүмбэр аймгийн Аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн ГСА-2023/11/НА-СТА-ТШЗ дугаар дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авч ажилласан үйл ажиллагааны нягтлан бодогчийг албан тушаалын сарын үндсэн цалингаар урамшуулсугай.

2. Урамшуулалд зарцуулах 827,799 төгрөгийг цалин сангаас гаргахыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч /Ө.Сайнхүү/-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Г.ГҮРРАГЧАА





### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 5/16

Говьсүмбэр аймаг

П.Гантуяад урамшуулал  
олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3 дахь хэсгийн 3.2.5, Говьсүмбэр аймгийн Аудитын байгууллагын 2022 оны сангийн тайлангийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн ГСА-2023/11/НА-СТА-ТШЗ дугаар дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авч ажилласан сангийн нягтлан бодогч П.Гантуяаг албан тушаалын сарын үндсэн цалингаар урамшуулсугай.

2. Урамшуулалд зарцуулах 827,799 төгрөгийг цалин сангаас гаргахыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч /Ө.Сайнхүү/- д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Г.ГҮРРАГЧАА



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 5/17.

Сүмбэр сум

**П.Гантуяад ажил хавсран  
гүйцэтгэсний нэмэгдэл олгох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Монгол Улсын сайнгын сайдын 2012 оны 12 дугаар сарын 18-ний 294 дүгээр тушаалын 3.6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогчийн сул орон тоон дээр Төрийн албан хаагчийн тусгай шалгалт зарлагдаж сул орон тоог нөхөх хүртэл хугацаанд, одоогоор шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагч байхгүй бөгөөд иргэд, даатгуулагчдын тэтгэвэр тэтгэмжийг саадгүй олгох, төрийн албаны тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахын хүрээнд Сангийн нягтлан бодогч, ЭМД-ын байцаагч П.Гантуяатай зөвшилцсөний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогчийн ажлыг 6 сарын хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. П.Гантуяад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг гэрээний дагуу 352,112 (гурван зуун тавин хоёр мянга зуун арван нэг) төгрөгөөр тооцож олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

3. П.Гантуяад санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг хийж гүйцэтгэхийг үүрэг болгосугай.



ДАРГА

Г.ГҮРРАГЧАА



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 518

Сүмбэр сум


**Э.Сарантуяад ажил хавсран  
гүйцэтгэсний нэмэгдэл олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэмж, сайн дурын даатгалын байцаагч Э.Сарантуяаг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн няравын ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2.Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 40% тооцон олгохыг Төлөвлөлт нэрийн дансны мэргэжилтэн, үйл ажиллагааны нягтлан бодогч (Ө.Сайнхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Няравын албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийн хүрээнд чанартай гүйцэтгэж ажиллахыг Тэтгэмж, сайн дурын даатгалын байцаагч (Э.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ГҮРРАГЧАА

## ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 03 сарын 27-ны өдөр

№ 01

Энэхүү Хөдөлмөрийн гэрээ (цаашид Гэрээ гэх)-г Нэг талаас Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 2-р багт байрлах, Нийгмийн даатгалын хэлтэс нь /байгууллагын нэр/ түүнийг Хэлтсийн дарга Ганхүү овогтой Гүррагчаа үндсэн дээр төлөөлөн /төлөөлсөн хүний албан тушаал, нэр/ /цаашид Ажил олгогч гэх/, Нөгөө талаас Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 2-р багт оршин суух, КЛ77112100 регистрийн дугаартай Пүрэв овогтой Гантуяа /цаашид Ажилтан гэх/ нар (хамтад нь Талууд гэх) Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэн хэлэлцэн тохирч, энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Ажил олгогч болон Ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээний хавсралтууд болох Ажилтны зүгээс гаргасан нууцын баталгаа болон хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, гэрээний сунгалт зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### 2. Хөдөлмөрийн гэрээний хугацаа

2.1. Хөдөлмөрийн гэрээний эхлэх хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 01 –ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

2.2. Гэрээний хүчинтэй хугацаа: 6 сар

2.3. Талууд гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах талаар хэн нэгэндээ санал тавиагүй бол энэхүү гэрээний хугацааг нэг жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно. Энэхүү нэг жилийн хугацаанд гэрээг талуудын аль нэгний саналаар цуцлаагүй бол уг гэрээний хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно.

### 3. Үндсэн нөхцөл

#### 3.1. Гүйцэтгэх ажил үүрэг

3.1.1. Ажлын байр: Нийгмийн даатгалын хэлтэс

3.1.2. Ажилтны албан тушаал: Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч

3.1.3. Ажилтны хариуцах ажил, үүрэг: Ажилтны эрхлэх ажил, албан тушаал дахь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхээс гадна шууд болон шууд бус удирдлагаас өгсөн бусад үүрэг, даалгаврыг хийж гүйцэтгэнэ.

3.1.4. Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

3.1.5. Ажлын цаг: 8 цаг

I. Ажлын өдөр : Даваа гарагаас Баасан гараг хүртэл 5 хоног байна.

II. Хоногт ажлын 8 цагаар тооцон долоо хоногийн 40 цаг ажиллана.

III. Ажил эхлэх цаг 8:30 цагт байна. Үдийн завсарлага 12:30 цагт байна.

IV. Ажилтны ажлын цагийн хуваарь нь удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хүний нөөцийн бодлогын дагуу уян хатан байж болно.

V. Ажил тасралтгүй явагдах зарчмыг хангах зорилгоор Ажилтан хоцрох, эрт явах, ажил дээр байхгүй байх цагуудыг удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.

3.2. Цалин 3.2.1. Ажилтны нэг сарын үндсэн цалин **331119** /гурван зуун гучин нэгэн мянга нэг зуун арван есөн төгрөг/ байна.

3.2.2. Ажилтны үндсэн цалингаас Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгана.

3.2.3. Ажил олгогч нь Ажилтны үндсэн цалинг сар бүрийн 15 ба 30-ны өдрүүдэд 2 (хоёр) хуваан олгоно. Хэрэв цалин олгох өдөр нь баярын болон амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөр олгоно.

3.2.4. Илүү цагаар ажилласан болон бүх нийтийн амралтын бусад өдрөөр ажилласан тохиолдолд нөхөж амраана.

### 3.3. Амралт

3.3.1. Амралтын өдөр, бүх нийтийн баярын өдрүүдээр Ажилтан амралт эдэлнэ. Ажлын шаардлага, нөхцөл байдлаас шалтгаалан ажилласан тохиолдолд нөхөж амраана.

3.3.2. Ажил олгогчийн баталсан ээлжийн амралтын журмын дагуу ээлжийн амралт олгоно. Ажилтан ээлжийн амралтыг биечлэн эдэлнэ.

## 4. Ажилтны эрх, үүрэг

### 4.1. Ажилтан дараах эрхийг эдэлнэ.

4.1.1. Ажилтан нь Ажил олгогчоос ажлын байранд эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангуулах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал зэрэг зүйлсээр бүрэн хангуулах эрхтэй.

4.1.2. Ажилтан нь Ажил олгогчоос гүйцэтгэх ажлын талаар заавар удирдамжаар хангуулах эрхтэй.

4.1.3. Ажилтан ажлын байран дээр ажил үүрэгтэй холбоотой асуудал болон түүний шийдлийн тухай шууд удирдлагад чөлөөтэй илэрхийлж, хэлэлцэх эрхтэй.

4.1.4. Гэрээгээр тохиролцсон цалин хөлсийг цаг тухай бүрд авах, амрах, "Хөдөлмөрийн тухай хууль", түүнд нийцүүлэн гаргасан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ээлжийн амралтаа эдлэх, тэтгэвэр, тэтгэмж болон туслалцаа дэмжлэг авах;

### 4.2. Ажилтан дараах үүргийг хүлээнэ.

4.2.1. Хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахиж, өөрийн ажил үүрэгтэй холбогдсон бүх шаардлагыг бүрэн биелүүлж, боломжит өндөр бүтээмжээр ажиллах үүрэгтэй.

4.2.2. Ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэнэ.

4.2.3. Мэргэжил, ур чадвараа байнга дээшлүүлэн идэвх санаачилгатай ажиллах үүрэгтэй.

4.2.4. Хамт олны уур амьсгалыг эерэг байлгаж, дэг журмыг хангахад анхаарч, ёс зүйн минимум стандарт, харилцааны соёлтойгоор ажиллах үүрэгтэй.

4.2.5. Эрс илэн далангүй байх, энэрэнгүй байх зарчмыг баримтлан ажиллах үүрэгтэй.

4.2.6. Ажилтан нь байгууллагын дэг журмыг сахих ёстой бөгөөд байгууллагын нэр хүндийг унагасан үйлдэл хийхийг хориглоно.

## 5. Ажил олгогчийн эрх, үүрэг

## 5.1. Ажил олгогч дараах эрхийг эдэлнэ.

5.1.1. Хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан баталж, мөрдүүлэх ба хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч, түүний биелэлтэд байнга хяналт тавьж ажиллах эрхтэй.

5.1.2. Ажилтнаас Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.

5.1.3. Хөдөлмөрийн хуульд заасны дагуу болон энэхүү гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу Ажилтанд хариуцлага хүлээлгэх эрхтэй.

## 5.2. Ажил олгогч дараах үүргийг хүлээнэ.

5.2.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг журмыг баримтлан ажилтныг ажлын аятай нөхцөлөөр хангах, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа болон бусад зүйлээр бүрэн хангах үүрэгтэй.

5.2.2. Хөдөлмөр, цалин хөлсний норм, нормативыг тогтоох журам, аргачлал боловсруулж, хөдөлмөрийн хөлсний хэмжээг анх тохирсноос доошлуулахгүй, нэмэгдүүлэх бодлого баримталж ажилтны хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлсийг цаг хугацаанд нь олгох үүрэгтэй.

5.2.3. Хөдөлмөрийн харилцааны хүрээнд Ажилтанд хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

5.2.4. Ажилтныг хууль тогтоомжийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, хуульд заасан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох журмын дагуу төлөх үүрэгтэй.

5.2.5. Ажилтанд эзэмшсэн боловсрол, мэргэжил, мэргэшлийн төвшин, ур чадвараа дээшлүүлэх хичээл, сургалт болон бусад арга хэмжээнд хамрагдах бололцоог гаргаж өгөхөд ямагт анхаарах үүрэгтэй.

## 6. Талуудын хариуцлага

### 6.1. Ажил үүргийн зөрчил

6.1.1. Ажил олгогч нь Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад заавар, журам болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй ажилтанд гаргасан зөрчлийн шинж чанар, түүний давтамж, учирсан хохирол, хугацааг харгалзан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 131 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.

### 6.2. Эд хөрөнгийн хариуцлага

6.2.1. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан ажилтан, албан тушаалтанд бусад төрлийн шийтгэл (сахилгын, захиргааны, эрүүгийн гэх мэт) оногдуулсан эсэхийг үл харгалзан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 132, 133, 135 дугаар зүйлд заасан журмын дагуу эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Ажилтан нь байгууллагын нууцыг задруулсан тохиолдолд Хөдөлмөрийн гэрээг цуцлахаас гадна түүнээс үүдсэн хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээж барагдуулна.

## 7. Гэрээ дуусгавар болох, цуцлах

23

7.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр энэхүү гэрээг дуусгавар болгоно.

7.2. Хөдөлмөрийн гэрээг дараах үндэслэлээр цуцална:

7.2.1. Ажилтан дараах байдлаар гэрээг хугацаанаас өмнө цуцлах санал гаргана:

7.2.1.1. Энэхүү гэрээг ажилтны санаачилгаар цуцлахаар бол ажил олгогчид 30 хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлэх ба эс тэгвээс ажилтан нь ажил олгогчид нэг сарын цалинтай тэнцэх цалинг буцааж төлснөөр гэрээг цуцалсанд тооцно.

7.2.1.2. Ажилтан хүндэтгэн үзэх шалтгаантай ба ажлаас чөлөөлөх хугацааг талууд тохиролцсон бол 30 хоногоос өмнө гэрээг цуцалж болно.

7.2.2. Ажил олгогч дараах нөхцөлүүдийн аль нэг бүрдсэн үед гэрээг хугацаанаас өмнө цуцална:

7.2.2.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1-д заасан үндэслэлүүдийн аль нэг бүрдсэн тохиолдолд,

7.2.2.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.4-т заасан ноцтой зөрчил гэдэгт дараахыг ойлгоно:

а. Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь нотлогдсон.

б. Хөдөлмөрийн сахилгын болон дотоод журамд заасан зөрчлийг давтан гаргасан.

в. Ажилтан нь үйлчлэгч, харилцагч болон хамтран ажиллагсадтайгаа бүдүүлэг харьцсан бөгөөд Ажлын байранд ёс зүйн хэм хэмжээг үл сахиж, аливаа зохисгүй үйлдэл гаргасан.

г. Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад зээл, бэлэн мөнгө олгосон, үнэ төлбөргүй үйлчилсэн. Байгууллагын хөрөнгө, нэр хүндээр хувийн бизнес хийсэн.

д. Байгууллагын үйл ажиллагааны стратеги, хөтөлбөр, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзсан, хамт олны дунд болон бусад байгууллагад худал мэдээ, мэдээлэл, байгууллагын нууцыг тараасан нь тогтоогдсон.

## 8. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Энэ гэрээнд талууд харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

